



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 321

Улаанбаатар хот

Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын хохирол үнэлэгч “Сүлд үнэлгээ” ХХК Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, 5 дугаар хороолол, Чин ван Ханддоржийн гудамж, 52/1А тоотод даатгалын төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.

2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглүүлж холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Сүлд үнэлгээ” ХХК /П.Одхүү/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН